

БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Ч.МӨНХТУЯА

2024 оны 05 дугаар сарын 29-ны өдөр

АГААРЫН ХӨЛГИЙН ШАТАХУУН СУМЛАГЧ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. АВТОМАШИН

1.1. Ерөнхий шаардлага

Агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэгч автомашин нь ашиглалтын хувьд найдвартай, техникийн үйлчилгээ явуулахад хялбар байхын дээр цахилгаан болон гидравлик тоноглолын талаар хамгийн сүүлийн үеийн технологи ашиглан хийгдсэн байна.

Манай орны цаг агаарын нөхцөл нь жилийн дөрвөн улиралдаа огцом өөрчлөгддөг, агаарын хэм нь өвөлдөө -40°C , зундаа $+40^{\circ}\text{C}$ хүрч хэлбэлздэг тул автомашин, тоноглолын эд ангиуд дээрх цаг агаарын нөхцөлд тохирсон.

Уг автомашин нь 2024 онд үйлдвэрлэгдсэн, MNS4598:2020, MNS4599:2003 стандартын шаардлагуудыг хангасан байна.

1.2. Техникийн үзүүлэлт

Үйлдвэрлэсэн он:	2024 оны /шинэ/
Зориулалт:	Агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэгч
Хөдөлгүүрийн төрөл:	Дизель
Цилиндрийн тоо:	4 буюу түүнээс дээш
Жолооны хүрдний байрлал:	Зүүн буюу LHD
Суудлын тоо:	Жолооч+Зорчигч
Жолооны механизм:	Гидро хүчлүүртэй байх
Тоормосны систем:	Хий болон гидравлик байх
Хаалганы тоо:	Зорчигчийн хаалга+Жолооч
Тэнхлэг:	4x2 эсвэл 6x4

1.3. Нэмэлт тоноглол

- Хүйтний улиралд жолоочийн бүхээгийг дулаацуулах систем байх
- Дулааны улиралд жолоочийн бүхээгийг агааржуулах систем A/C байх
- Жолоочийн болон зорчигчийн хаалганы шил нээгдэг байх
- Тоноглол болон хөдөлгүүрийг унтраах ослын унтраалгатай байх
- Анхааруулах дуут дохиотой байх
- Ухрах үед анхааруулах дуут дохиотой байх
- Мотоцагийн тоолууртай байх
- Цахилгаан тоноглын утас, холболтууд ус болон зэврэлтээс хамгаалагдсан байх
- Хажуу тал болон арын харах тольтой байх
- Маяктай байх /чанарын шаардлага хангасан/
- Арын хэсэгт нэмэлт гэрэлтүүлэгтэй байх
- Түлхүүр багажтай байх /дугуйн торцов болон түлхүүрийн ком/
- Нөөц дугуйтай байх
- Домкрат болон дугуйн ивүүртэй байх
- Эмийн сан, ослын зогсолтын тэмдэгтэй байх

- Галын хор нь торхоны багтаамжид тохирсон хүчин чадалтай байх /кабинд 1, торхонд 2 ширхэг/

2. ТУСГАЙ ТОНОГЛОЛ

2.1. Ерөнхий шаардлага

Агаарын хөлгийг шатахуунаар цэнэглэгч автомашин нь торх, насос, түлшний нарийн шүүр, сумлагааны шланг, хошуу, шланг хураах дамар, шатахуун буулгах хаалт, хянах хэмжих хэрэгсэл зэргээр тоноглогдсон байна.

Цэнэглэгч автомашин нь Агаарын хөлгийн шатахууны чанарын хяналт ба сумалгаа хийх үйл ажиллагаанд тавих шаардлага MNS 6591-2016, стандарт, IATA JIG-2 зөвлөмж, EN 1361, IATA АНМ 980, 910, 913, 915 шаардлагуудыг хангасан байна.

2.2. Торхны үзүүлэлт

- Торхны багтаамж нь 8000 литр ба түүнээс дээш байх
- Материал үл зэврэх гангаар хийгдсэн байх
- Тусгай зориулалтын будагтай байх баталгаат хугацаа 5 жил байх
- Торхны люкний хэмжээ нь 600мм хэмжээтэй цэвэрлэгээ, үйлчилгээ хийх боломжтойтой байх
- Люкний таг нь битүүмжлэлтэй, давхар хамгаалах тагтай байх
- Амьсгалах болон хамгаалалтын хавхлагатай байх
- Цалгианы хамгаалалтай байх
- Түлшний түвшин заагчтай байх

2.3. Тусгай тоноглол

- Түлшний насосны хүчин чадал 800л/мин болон түүнээс дээш байх
- Түлшний даралт нь 3,5 bar дээшгүй байна.
- Түлшний систем нь дотоод эргүүлэг хийх системтэй байх
- Бөмбөглөн хаалтнууд нь зэвэрдэггүй материалаар хийгдсэн байна.
- Сумалгааны шланг нь олон улсын EN 1361, EI 1529 стандарт шаардлага хангасан (Elaflex HD 50C-LT) эсхүл түүнтэй дүйцэх, түлшний зориулалттай, дотор диаметр 50мм, 25м урттай, нэг шлангтай 2 хошуугаар сумалгаа хийх боломжтой, шилжүүлэгчтэй байх
- Доороос сумлах хошуу нь Meggitt F145 маркийн эсхүл түүнтэй дүйцэх, SAE AS5877 стандарт шаардлага хангасан автомат мэдрэгчтэй, механик хольцыг шүүх 250микрон шүүртэй, тоос шорооноос хамгаалах тагтай байх
- Дээрээс сумлах хошуу нь Elaflex ZVF-40 маркийн эсхүл түүнтэй дүйцэх, автомат мэдрэгчтэй, механик хольцыг шүүх 250микрон шүүртэй, тоос шорооноос хамгаалах битүүмжлэл сайтай тагтай байх
- Түлшний 700л/мин болон түүнээс дээш нэвтрүүлэх чадвартай нарийн шүүртэй, FAUDI FW-10-H-T-3/559 маркийн эсхүл түүнтэй дүйцэх, олон улсын EI 1590 стандарт шаардлага хангасан шүүх нарийвчлал 5мкм болон түүнээс илүү нарийвчлалтай байх
- Түлш шахах, сорох шугам, хаалт, буулгах хаалт нь стандарт холбогчтой байх
- Түлшний нөөц хянах болон зарлага гарахад ашиглах тоолуур нь эрх бүхий газрын баталгаажуулалтад хамрагдсан байх
- Тоолуур нь тухайн сумалгааны түлшний хэмжээг болон нийт гарсан зарлага заах заагчтай, тэгэлдэг системтэй, нэвтрүүлэх чадвар нь 800л/мин дээшгүй, алдааны нарийвчлал +/- 0,25% хэтрэхгүй байх
- Түлшний тундас авагч савтай байх ба хэмжээ нь 70 литрээс ихгүй байна
- Торх, түлшний шүүрнүүдээс дээш авах цэгүүдтэй байх
- Түлшний даралт тохируулагч цахилгаан клапантай байх

- Сумлагааг богино хугацаанд зогсоох удирдлагатай байх /DEADMAN/
- Аюулгүй ажиллагааны INTERLOCK системтэй байх
- Ослын үеийн унтраалгуудтай байх /кабин, удирдлагын бүхээг/
- Газардуулгатай байх /сумалгааны хошуу болон автомашин/
- MNS 6591-2016 стандарт шаардлагын 7.3 заалтыг хангасан түлшний чанарыг нүдээр хянах битүү системтэй байх

3. ХҮЛЭЭН АВАХ

Нийлүүлэгч нь зөвхөн шаардлагад нийцсэн техникийн үзүүлэлтийг хангасан автомашиныг иж бүрдлийн хамт нийлүүлнэ.

ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу шалгаж, хүлээн авах актыг үйлдсэнээр автомашиныг хүлээн авсанд тооцно.

Баталгаат хугацаа нь ажил хүлээн авах комисс нь актад гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 24 сар.

Ачааг хүргэх цэг: Улаанбаатар хот, Буянт-Ухаа, Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба.

4. БУСАД НӨХЦӨЛ

- Автомашины ашиглалт, сүүлийн үеийн нэмэлт тоноглол болон засвар үйлчилгээний талаар үйлдвэрлэгчийн сургалтыг үйлдвэр дээр зохион байгуулах /4 хүн сургалтад хамруулж гарах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцах/
- Ашиглалтын болон техник үйлчилгээ, засварын гарын авлага, сэлбэгийн каталоги монгол болон англи хэл дээр байх /Owner manual, Parts catalog, Service manual/
- Нэмэлтээр сумалгааны шлангнууд /3ш/, дээрээс болон доороос сумлах хошуу тус бүр /1ш/, хөдөлгүүрийн тосны шүүр /2ш/, түлшний шүүр /2ш/, агаар шүүгч /2ш/, дээж авагч /1ш/, люк болон насосны сальник, жийрэг /1 ком/ , зэвэрдэгүй материалаар хийгдсэн хувин /2 ш/, шатахууны манометр /1 ком/ зэрэг засвар үйлчилгээнд шаардлагатай сэлбэг материалыг үнэгүй дагалдуулах


Техникийн тодорхойлолт бэлтгэсэн:

Иргэний нисэхийн үндэсний төвийн
Үйлдвэрлэл, үйлчилгээний газрын дарга,
Үнэлгээний хорооны дарга:



Г.Мөнгөнхуяг

Иргэний нисэхийн үндэсний төвийн Үйлдвэрлэл,
үйлчилгээний газрын Орон нутгийн аэродром, нисэх
буудлын технологи үйл ажиллагаа хариуцсан
ахлах технологич мэргэжилтэн,
Үнэлгээний хорооны гишүүн:




Б.Шаравжамц

“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв”
Төрийн бус байгууллагын гишүүн,
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:

 М.Оргил

“ХУД Яармаг” Төрийн бус байгууллагын гишүүн,
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:

 М.Уранчимэг

Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө
оруулалт, захиалагчийн албаны Худалдан авах
ажиллагааны тасгийн ахлах мэргэжилтэн,
Үнэлгээний хорооны нарийн бичиг:

 Б.Мөнхбаатар